

АНХААРЛЫН ТӨВД

О.ЧАНЦАЛДУЛАМ

"Их 7" бүлгийн орнуудын дээд хэмжээний уулзалт энэ жил Японы Хирошима хотод боллоо. АНУ, Япон, Их Британи, Герман, Франц, Итали, Канад улс болон Европын Холбоо багтдаг энэ бүлгийн дээд хэмжээний уулзалтын дараа Хятадад хандсан мэдэгдэл болон Оросын эсрэг нэмэлт хоригийн тухай мэдэгдэл гаргав. "Их 7" бүлэг нэмэлт хориг тавих замаар ОХУ-д үзүүлэх шахалтаа нэмэгдүүлэхээр болжээ. Тэр дундаа Украины дайнд ашиглах боломжтой бүтээгдэхүүнд хязгаарлалт тогтоохоор ярилцсан байна. Тухайлбал, АНУ Орос болон бусад холбоотон улсын 70 хувь хүн ба компанийн эсрэг экспортын хориг тавихаар төлөвлөжээ. Уг хориг өртсөн хувь хүн болон компаниуд АНУ-ын Худалдааны департаментын хар жагсаалтад бичигдэх аж. Түүнчлэн "Их 7" бүлгийн гишүүн орнууд ОХУ-ын Засгийн газрын хөрөнгийг дайн дуустал царцаасан хэвээр байлгана гэжээ. Мөн ОХУ-ын очир эрдэнийн худалдааг хянахад хамтран ажиллахаар тохиролцсон байна.

В.ЗЕЛЕНСЬКИЙН УРИАЛГА

Украины Ерөнхийлөгч Володимир Зеленский ОХУ-ыг сүүлчийн эзлэн түрэмгийлэгч болгохыг "Их 7"-д уриалжээ. Украины Ерөнхийлөгч "Оросыг сүүлчийн эзлэн түрэмгийлэгч болгон түүхэнд үлдээх замаар дэлхий дахинд энх тайван тогтоохыг уриалж байна. Бид бусад болзошгүй түрэмгийлэгчдийг мохоох болно. Тэд дэлхий нийт энх тайвны төлөө шийдэмгий зогсож байгааг хараад дайн эхлүүлэх нь ямар утгагүй зүйл болохыг ухаарах болно" гэв. Түүнийг Хирошимагаас тун олзтой буцаж байгааг шинжээчид онцолсон. Яаруу бусан Зеленский зарим улсын тэргүүнтэй уулзаж амжаагүй аж. Бразилын Ерөнхийлөгч Луис Инасиу Лула да Силва Хирошима хотод болсон "Их 7"-гийн дээд хэмжээний уулзалтын үеэр Украины Ерөнхийлөгч Володимир Зеленскийтэй хийх ёстой байсан уулзалтад Зеленский ирээгүйг мэдэгджээ. Бразилын Ерөнхийлөгч Луис да Силва "Миний урам хугараагүй, харин бүхмидсэн. Яагаад гэвэл түүнтэй уулзамаар байсан юм" гэсэн байна. Тэрбээр мөн Володимир Зеленскийг "Тэр юу хийж буйгаа мэддэг том болсон хүн" гэжээ. Үүнээс гадна Бразилын тал Украины төлөөлөгч нар саатсан талаарх мэдээллийг авсан байсан талаар Луис Инасиу Лула да Силва ярьжээ. Бразилын Ерөнхийлөгч тийнхүү Вьетнамын Ерөнхийлөгчийг хүлээн авч уулзаад Украины Ерөнхийлөгчийг хүлээсэн боловч Владимир Зеленский ирээгүй гэнэ. Лула да Силва өмнө нь "Украины сөргөлдөөн нь дэлхийн хамтын нийгэмлэгийн анхаарал хандуулах шаардлагатай байгаа цорын ганц сөргөлдөөн биш" гэж мэдэгдсэн билээ.

ҮЙЛ ЯВДАЛ

В.ЗЕЛЕНСЬКИЙН БНСУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ХҮСЭЖ БҮЙ ЗЭВСГИЙН ЖАГСААЛТАА ӨГӨВ

БНСУ-ын Ерөнхийлөгч Юн Сог Ёлоос Украины Ерөнхийлөгч Володимир Зеленский түүнд хүсэж буй хөнөөлт бус зэвсгийн жагсаалтаа өгсөн талаар мэдэгджээ. "Енап" агентлагийн мэдээлснээр Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч "Хөнөөлт бус зэвсгийн тухайд В.Зеленский өнөөдөр надад хэсэгчилсэн жагсаалтаа өгсөн" гэсэн байна. Тэрбээр Украины Ерөнхийлөгчийн хүсэлтийн асуудлаар сайтар бодолцох тухайгаа хэлжээ. Тэгвэл үүний өмнө Сөүл хотод суугаа ОХУ-ын Элчин сайд Андрей Кулик "Өмнөд Солонгос Киевт зэвсэг нийлүүлэх нь ОХУ болон БНСУ-ын харилцаанд улаан шугам болно" гэж мэдэгдсэн билээ. Харин Цагаан ордны зүгээс АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден

БНСУ-ын Ерөнхийлөгч Юн Сог Ёлоос Украиныг дэмжих тухай яриа сонсоно гэж найдаж байгаа талаар мэдээлжээ. Украины зүгээс БНСУ-аас хүсэж буй хөнөөлт бус зэвсэг гэдэг нь хүний амийг хөнөөлгүйгээр, хүний биед бага хэмжээний гэмтэл учруулах замаар дайсны талыг эсэргүүцэх чадваргүй болгодог тусгай зэвсэг юм. Хөнөөлт бус зэвсгийн эд хөрөнгөд учруулах хохирол нь мөн адил бага байдаг. Уг зэвсгийг аврах ажиллагаа, эмх замбараагүй байдал үүсэх, дайнд олзлогдсон хүмүүсийг хянах, шалган нэвтрүүлэх цэг болон цувааг хамгаалах, хүмүүнлэгийн тусламж хүргэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон иргэдийн зүгээс зэвсэглэн довтлох үед ашигладаг.

# "ИХ 7" ДАЙНЫГ ДУУСГАХАД ОХУ-ЫГ ШАХАХЫГ УРИАЛАВ



АНУ-ААС УКРАИНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ

АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден "Их 7"-гийн уулзалтын үеэр Украинд 375 сая ам.долларын зэвсгийн шинэ тусламж үзүүлэхээ мэдэгдсэн байна. Мөн "F-16" сөнөөгч нисэх онгоцны нисгэгчдийг Украинд бэлдэж өгөхөө амлав. Үүний өмнө Их Британийн эрх баригчид энэ зун Украины нисгэгчдийг нислэгийн үндсэн курст хамруулж сургахаа амалсан. Үүний зорилго нь Украины нисгэгчдэд янз бүрийн төрлийн нисэх онгоцтой харьцах ур чадварыг олгох явдал юм. Энэхүү сургалт нь Украинд илүүд үздэг "F-16" сөнөөгч онгоцыг нийлүүлэх асуудлаар Их Британи бусад улстай хамтран ажиллаж байгаатай холбоотой гэж шинжээчид дүгнэсэн байна. Мөн Украин улс байлдааны эрчимтэй үйл ажиллагаанд бэлтгэж байгааг онцолжээ. Украины Ерөнхийлөгч Их Британийн Ерөнхий сайд Риши Сунактай хэлэлцээ хийсэн тухайгаа Телеграм хуудсаараа дамжуулан Их Британи бол Украины Зэвсэгт хүчний чадавхыг газар болон тэнгэрт өргөжүүлэх тал дээр "удирдагч" гэдгийг онцолсон юм.

БНХАУ-Д ХАНДСАН УРИАЛГА

"Их 7" бүлгийн уулзалтаар гишүүн орнууд дайныг дуусгахад ОХУ-ыг шахах, Тайванийн статусыг хүндэтгэх, шударга худалдаа хийхийг БНХАУ-д уриаллаа. Дээд хэмжээний уулзалтаар БНХАУ-д хандан хамтарсан мэдэгдэл гаргав. Аж үйлдвэржсэн долоон гүрний удирдагчид уг мэдэгдэлд Хятад улсад хор хөнөөл учруулах сонирхолгүй байгаагаа онцлоод илэн далангүй, тогтвортой харилцаа тогтоох хүсэл эрмэлзлээ илэрхийлжээ. Тэд хамтарсан мэдэгдэлдээ "Украинд явуулж буй эзлэн түрэмгийлэх дайнаа зогсоож, Украины нутаг дэвсгэрээс ямар нэгэн болзол нөхцөлгүйгээр цэргээ нэн даруй, бүрэн гаргах асуудлаар Оросын талд шахалт үзүүлэхийг Хятад улсад уриалж байна. Газар нутгийн бүрэн бүтэн байдал, НҮБ-ын дүрэмд суурилсан иж бүрэн, эрх тэгш, урт хугацааны энх тайван байдал тогтоохын төлөө хүчин чармайлт гаргахыг БНХАУ-аас хүсэж байна" гэжээ. БНХАУ-ыг дэлхийд гүйцэтгэх үүрэг,

эдийн засгийн хүчин чадал нь улсыг уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал, ядуу буурай орнуудын өр зээл, санхүүжүүлэх хэрэгцээ, дэлхий дахины эрүүл мэнд, эдийн засгийн тогтвортой байдал зэрэг хүн төрөлхтний өмнө тулгарч буй асуудлууд дээр хамтран ажиллах шаардлага үүсгэж байгааг "Их 7" онцолсон байна. Мөн Зүүн болон Өмнөд Хятадын тэнгисийн бүс нутагт цэрэг зэвсгийн байр сууриа бэхжүүлж, Тайванийн өөртөө засаглах эрхэд аюул занал учруулж буйд нь ноцтой санаа зовниж буйг хамтарсан мэдэгдэлд өгүүлжээ. Тайванийн асуудлыг хүчээр биш, энх тайван замаар шийдвэрлэхийг Бээжингийн эрх баригчдад уриалсан мэдэгдэлд мөн Төвөд, Хонконг, Шинжаан Уйгарын хүний эрхийн асуудалд санаа зовж буйгаа илэрхийлэв. Үүний зэрэгцээ "Их 7" нь худалдаа, хөрөнгө оруулалтыг зүй бус аргаар хязгаарлах, технологи, мэдээллийг хууль бусаар шилжүүлж авах зэрэг эдийн засгийн хор хөнөөлтэй үйлдлүүдтэй тууштай тэмцэхээ анхааруулжээ.

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ УРИЛГА

Огноо: 2023.05.22

Захиалагч: "Улаанбаатар лифт" НӨҮГ

Гүйцэтгэх ажлын нэр: Улаанбаатар хотын Явган хүний 4 гүүрэн гарцын 8 цахилгаан шатны арчлалт, засвар үйлчилгээ.

Ажлын даалгавар:

- Улаанбаатар хотын Явган хүний 4 гүүрэн гарцын 8 цахилгаан шатны арчлалт, цэвэрлэгээ, засварыг гүйцэтгэх.
- Засвар хийхэд шаардлагатай сэлбэг материалыг нийлүүлж, угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгэх, тасралтгүй хэвийн ажиллагааг хангах.
- Хүйтний улиралд цахилгаан шатны хонгилд халаагуур суурилуулан цахилгаан шатнуудыг хэвийн ажиллуулах.
- 2023.04.15-2024.04.15-ны өдөр хүртэлх хугацаанд цахилгаан шатнуудыг хариуцан хэвийн ажиллуулж, 8 лифтчингийн ажлын хөлсийг сар бүр хугацаанд нь олгох.

Шалгаруулах хугацаа: Гүйцэтгэх ажлыг 2023 оны 05-р сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө үнийн санал, шаардлагатай баримт бичгийг ирүүлсэн байх ба шалгаруулалтыг 2023 оны 05-р сарын 25-ны өдрийн 09 цаг 30 минутад зохион байгуулна.

Сонирхсон этгээд дараах хаягаар гүйцэтгэх ажилтай холбоотой тодруулга, үнийн санал болон дэлгэрэнгүй мэдээлэл авах хүсэлт илгээнэ.

Монгол, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Намъяанжугийн гудамж, 13 дугаар хороолол, 15 дугаар хороо, "Улаанбаатар лифт" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын байр  
E-mail: ulaanbaatarlift1@gmail.com

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2023 оны 05 дугаар сарын 22

Тендер шалгаруулалтын нэр: "Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, явгалах замын ээлжит засвар (Өмнөговь, Даланзадгад төв сум)-ын ажил хийж гүйцэтгэх

Тендер шалгаруулалтын дугаар: ИНЕГ/ХО/04

[Иргэний нисэхийн ерөнхий газар] нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг ["Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, явгалах замын ээлжит засвар (Өмнөговь, Даланзадгад төв сум)-ын ажил]-ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: "Үгүй"

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш [30] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба [7,500,500.00 (долоон сая таван зуун мянга таван зуу)] төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг [2023.06.22-ны өдрийн 09.30 цаг]-аас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг [2023.06.22]-ны өдрийн, [10.00]-т зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: "Эрхгүй"

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: "Үгүй"

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

[Тоон гарын үсэг ашиглан tender.gov.mn цахим системээр тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлт ирүүлэх]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2023-05-23

Дугаар: ДОАХГСЗДТГ202301011

Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендер оролцогчдоос "То Вангийн өв соёлын өргөө" байгуулах ажилд битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа бөгөөд цахим тендерийн урилга 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр www.tender.gov.mn хаягт нийтлэгдсэн тул дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2021, 2022 он/-ын борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: санал болгож буй үнийн дүнгийн 20 хувиас багагүй

Сүүлийн жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2021, 2022 оны аль нэгэнд төсөвт өртгийн 30 хувиас багагүй дүнтэй ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна

Тендерийн төсөвт өртгийн 1 хувьтай тэнцүү төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг 30 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй

Давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймгийн Халхгол сумын 1-р баг, Дорнод аймгийн Халхгол сумын ЗДТГ-ын 2 давхар, 202 тоот Архив бичиг хэргийн ажилтан  
Утас: 80580889  
Цахим шуудан: erdenebatnsgelzin@gmail.com  
Цахим хуудас: www.tender.gov.mn